

## 3.4 Ажлын байр устгах үйл ажиллагааны зааварчилгаа

### 3.4 Ажлын байр устгах үйл ажиллагааны зааварчилгаа


Энэ үйлдлийг буруу үүсгэсэн болон татан буугдсан ажлын байрыг устгахад ашиглана.

Ажлын байр устгах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. **Ажлын байр** үйл ажиллагааг сонгоно.
2. Үндсэн цонхны ажлын байрны жагсаалтаас устгах ажлын байрыг идэвхжүүлнэ.
3. Үйлдлээс **Ажлын байр устгах** гэснийг сонгоно.
4. Ажлын байрыг устгана.

Ажлын байр устгах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **ажлын байр**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.



Хүний нөөцийн удирдлага

Байгууллагын бүтэц | Ажлын байр | Ажилтны жагсаалт | Шагнал | Цалингийн нэгтгэл


Ажлын байр

Ажлын байр хайх... | Дэлгэрэнгүй хайлт | Шинэ ажлын байр | Үйлдэл

№	Ажлын байр	Дотоод бүтэц	Ажил	Байнгын/Түр	Ангилал	Зэрэглэл	Орон т...	Ажлын байрны мэдээлэл		
18	Багш, бага ангийн /мэргэжлийн/	Сургалтын а...	Багш, бага а...	Байнгын	ТҮБД	ТҮБД-4	26	26	0	Идэвхтэй
19	Цэвэрлэгч, албан байгууллагын	Захиргаа, аж...	Цэвэрлэгч, а...	Байнгын	ТҮ	ТҮ-1	7	7	0	Идэвхтэй
20	Нарийн мужаан	Захиргаа, аж...	Нарийн муж...	Байнгын	ТҮ	ТҮ-2	1	1	0	Идэвхтэй
21	Бичиг хэргийн бусад туслах ажилтан	Захиргаа, аж...	Бичиг хэргий...	Байнгын	ТҮ	ТҮ-2	1	1	0	Идэвхтэй

Ажлын байрны мэдээлэл  
Ажлын байр засах  
**Ажлын байр устгах**

Цонхны баруун дээд хэсэгт байрлах үйлдэл дээр дарж ажлын байр устгах товчийг дарахад дараах дэд цонх нээгдэнэ.



Ажлын байр устгах


"Галч"-ыг устгахдаа итгэлтэй байна уу?

Хэрэв устгавал дахин сэргээх боломжгүй болно.

Тийм | Үгүй

Дэд цонхны **Тийм** гэсэн товчийг дарахад ажлын байр бүрэн устаж үндсэн цонхны жагсаалтаас хасагдана.

Хэрэв тухайн ажлын байранд хүн ажилд авч ажил эрхлэлт үүсгэсэн бол тухайн ажлын байрыг устгах боломжгүй гэсэн дараах дэд цонх нээгдэж анхааруулна.



**Санамж:** Ажлын байран дээр ажил эрхлэлт үүсч хүн ажилд авсан бол ажлын байрыг устгах боломжгүй байна. Энэ үед ажлын байран дээр үүсгэсэн ажил эрхлэлтийг цуцалсны дараа ажлын байрыг устгана.